



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/В

Улаанбаатар хот

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дах заалт, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Самсунг анагаах ухааны төв хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох гадаадын 2 эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Д.Оюунчимэг/-д даалгасугай.


САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080064

Эрүүл мэндийн сайдын  
2016 оны... сарын... өдрийн  
A/13... дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Жон Тэ Гүк Jun Tae Gook	БНСУ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГЭ0001622	Хүүхдийн зүрхний мэс засал	Эмчлэх	2016-09-04 2016-09-09 6 хоног
2.	Со Чон Мин Seo Jeong Meen	БНСУ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГЭ0001623	Хүүхдийн мэс засал	Эмчлэх	2016-09-04 2016-09-09 6 хоног